

ХҮН, ТҮҮНИЙ ҮҮСЛИЙН ШАЛТГААНЫ ТАЛААРХ ФИЛОСОФИ ЗАРИМ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Ц.Гомбосүрэн- МУИС, НШУС, Философийн тэнхим, доктор, профессор

Ж.Амарсанаа- Цагдаагийн Академийн багш, магистр,

Түлхүүр үгс: Хүний үүслийн шалтгааны талаархи философи баримтлалуудыг ангилахуй. Янз бүрийн шашны философи дахь хүний тухай асуудал. Хүний үүслийн асуудлаархи Ч.Дарвины сургаалын философи үндэс. Хүний үүсэлд холбогдох орчин үеийн эволюционис үзэл. Хүний үүслийн тухай орчин үеийн оккультив шинжлэх ухааны тайлбар

Энэхүү өгүүллийн зорилго нь хүн гэж юу болох, хүний үүсэл ямар шалтгаан бүхий тухай орчин үеийн философи, шинжлэх ухаан дахь янз бүрийн баримтлалыг бүлэглэж, улмаар хүний үүслийн талаархи оккультив мэдлэгийн олон чухал мэдээ сэлтийг шинжлэх ухаан хэрхэн үндэслэж буйг харуулахад чиглэв. Ийм зорилгын хэрэгжилт нь хүний үүслийн шалтгааныг авч үзэхэд нэн чухал нэг арга зүй болж өгдөг хувьслын тухай холбогдох үзлийг авч үзэхтэй уялдсан болно. Мөн хүний тухай философи сургаал олон чиглэлээр үүсэж, оршиж ирснийг бид товч боловч авч үзэхэд хүргэж байна.

Бидний хийсэн зарим судалгааны үр дүнгээс үзвэл түүхэн бодит байдлын ямар хүчин зүйлийг онцолсон байдлаараа хүний тухай философи сургаалууд дараах логик бүлэглэлд хуваагдана гэж болохоор юм. Үүнд: 1). *натуралист*; 2). *нийгэмчлэгч (социологичлогч)*; 3). *иррационалист*; 4). *шашны философийн*; 5). *оккультивизм ба спиритуализмд* үндэслэсэн гэх мэтээр хүний тухай философи сургаалуудыг ангилж болно. Ингээд өөрсдийн онцолсон ийм ангилалдаа багтдаг зарим гол философи сургаалын өвөрмөц арга зүйг авч үзье.

Натурализм. Хүний тухай натуралист үзэл философийн түүхийн бараг бүх үед ямар нэг байдлаар оршиж иржээ. Уг үзэл ялангуяа эртний грекчүүдийн сэтгэлгээнд чухал нөлөө бүхий байсан байна. Эртний грекийн анхан үеийн сэтгэгчид хүнийг төгс төгөлдөр зохион байгуулалтад орчлонгийн нэг чухал хэсэг мөн гэсэн үзлийг илэрхийлдэг байв. Улмаар Демокрит хүний биеийг төдийгүй сэтгэлийг (сүнснийг) атом, хоосон хоёроос тогтдог гэж тайлбарлажээ. Шинэ үеийн философид хүнийг натуралист байрнаас тайлбарласан гол философи нь материализм юм. Тухайлбал XIX зууны германы материализмын томоохон төлөөлөгч Л.Фейербах: хүн бол байгалийн бүтээгдэхүүн, хүний ухамсар бол гадаад ертөнц хүний тархинд туссан тусгал мөн гэж үзжээ.

Орчин үеийн философи үүссэнээс хойш, өөрөөр хэлбэл XIX зууны сүүлийн хагасаас хойш хүний тухай натуралист үзлийн хоёр хувилбар онцгой нөлөө бүхий болсон. Тэдгээрийн нэг нь социаль-дарвинизм мөн. Түүний үүднээс хүн ба нийгэм бол дээд зэргийн хөгжилтэй амьтдын хувьслын үргэлжлэл, үүнд уг хувьслын шинэ шат мөн. Тийм учраас хүн төрөлхтний амьдралд биологийн хуулиуд, ялангуяа амьдралын төлөөний тэмцэл, байгалийн шалгарал зэрэг хууль үйлчилдэг.

Харин нөгөө хувилбар нь хүн бол дутуу зэрэмдэг амьтан гэдэг Ф.Ницшегийн үзэл мөн. Тэрээр хүн гэж юу болох тухай философи ойлгоцоо 1883 онд хэвлүүлсэн “Заратустра ингэж өгүүлэв” зохиолдоо анх нэлээд тодорхой илэрхийлсэн байдаг. Уг зохиолд

бичсэнээр¹ Заратустра 30 нас хүрэхдээ төрсөн нутаг усаа орхин, ууланд очиж, тэндээ сэтгэл зүрхээ чагнасан бясалгалыг 10 жилийн турш орь ганцаараа хийсэн аж. Тэгээд нэг өглөө сэрэхэд л сэтгэл нь өөрчлөгдсөн байж; улмаар уулнаас буугаад ойд орон, зарим адал явдалтай тааралдан байж түүнээ туулаад хотод хүрч, наймааны захад олон хүн цугларсантай тааралджээ (энд гарч буй “төрсөн нутаг ус”, “уул”, “өглөө”, “ой”, “наймааны зах” гэх мэт илэрхийлэл тус бүр бол бодгаль юм уу бүлэг хүний сэтгэлийн жич жич төлвийг урлагийн аргаар зүйрлэсэн хэллэгнүүд байдаг бөгөөд гагцхүү манай өгүүллийн багтаамж тэдгээрийн агуулгыг тайлбарлах бололцоо өгөхгүй байна). Тэдгээр хүмүүс бол олсон дээрх үзүүлбэрийг сонирхохоор цугларан аж. Заратустра тэдэнд хандан ийн өгүүлэв: Үүнд: «Би та нарт үлэмж хүний тухай сургаал хэлье. Хүн бол бид туулан давах ёстой зүйл мөн. Түүнийг туулахын тулд та нар юу хийсэн бэ? Амьтны төрөл бүхэн өөрөөсөө дээш гарсан ямар нэг төрлийг хэдийн бий болгожээ. Гэтэл та нар түүнийг туулан давах нь бүү хэл энэ агуу давалгаанаас зайлж, адгуусан байдалдаа бушуухан эргэж очихыг хүсч байна гэж үү?»² хэмээн цугларагсдыг зэмлэдэг.

Энд өгүүлж буй “үзүүлбэрийн олс” гэгчийг Заратустрагийн амаар “гүүр” хэмээн Ф.Ницше бас нэрлэн дурдсан байдаг. Тэрхүү дамжих олс буюу гүүрээр хүнийг Ф.Ницше зүйрлэн илэрхийлсэн байна. Үүнд: «... хүнтэй харьцуулахад сармагчин юу билээ? Инээдмийн амьтан, гутамшиг биз дээ. Үлэмж хүний хувьд хүн бас тийм инээдмийн амьтан, гутамшиг байх ёстой.

Та нар өт хорхойноос хүн болох бүх замыг туулсан. Гэвч ихээхэн юм өтнөөс та нарт үлджээ. Урьд нэгэн цагт та нар сармагчин байсан. Гэхдээ хүн одоо ч гэсэн сармагчнаас илүү байж, үүгээрээ сармагчнаас ондоо юм»³ гэсэн үзлээр илэрч байна. Тэрээр энэ санаагаа зүйрлэн тодруулахдаа: хүн бол амьтан, хүн хоёрын дунд татсан олс, сармагчнаас үлэмж хүн болж шилжих гүүр мөн гэсэн байдаг⁴.

Нийгэмчлэгч үзэл. Хүний үүсэл, мөн чанарыг нийгэмчилж тайлбарласан сургаал философийн түүхэнд бас цөөнгүй гарч иржээ. Ийм үзлийг сурталчилж ирсэн анхны томоохон төлөөлөгчдийн нэг нь Аристотель юм. Тэрээр хүнийг “anthropods zoon politikon” (хүн бол хот улсын амьтан мөн) хэмээн томъёолжээ. Энэ бол эртний грекчүүдийн соёлыг бусад ард түмний соёлоос дээгүүр тавьдаг үзэлтэй уялдсан томъёолол мөн.

Түүнчлэн хүний үүсэл, хөгжлийн шалтгааныг социологчлох үзлийн үүднээс тайлбарлаж ирсэн нөлөө бүхий сургаалуудын нэг нь марксизм мөн. К.Маркс уг үзлийг философи онолын үүднээс үндэслэхдээ: “хүний мөн чанар бол бодгаль тус тусд байдаг хийсвэр зүйл бусаа. Жинхэнэдээ тэрээр нийгмийн харилцааны цогц мөн”⁵ гэсэн байна. Улмаар энэ санааг Ф.Энгельс “Мич хүн болоход хөдөлмөрийн гүйцэтгэсэн роль” хэмээх дуусаагүй зохиолдоо философийн үүднээс олон талаар үндэслэсэн байдаг. Марксист-ленинист онолчид К.Маркс, Ф.Энгельс нарын эл үзлийг арга зүй болгосон байр сууринаас хүний тухай бусад философи сургаалыг эрс шүүмжилж, өөрсдийн сургаалыг гүнзгийрүүлэн тайлбарлаж ирсэн байдаг.

¹ Так говорил Заратустра. Книга для всех и ни для кого.-Фридрих Ницше. Сочинения в двух томах. Том 2. М., 1990. Часть первая

² Там же, с. 8

³ Там же, с. 8

⁴ См. об этом там же, с. 9

⁵ К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. I боть. УБ., 1969. 2 дахь тал

Бас Ф.Ницше бол хүний үүсэл, тухайн оршин тогтнолыг дээр дурдсанчлан биологичлон тайлбарласны зэрэгцээ ирээдүйн хүний асуудлыг шинэ үнэлэмжтэй холбон тайлбарласан байдаг. Тийнхүү тэрээр ирээдүйн хүний асуудлыг шийдвэрлэхдээ нийгэмчлэгч үзлийн тодорхой хувилбарт үндэслэжээ.

Иррационалист үзэл. Шинэ үеийн философи дахь хүний тухай иррационалист үзлийн анхны томоохон төлөөлөгч нь мөн хэмээн Ф.Ницшег бас дурдаж болохоор байдаг. Учир нь хүн бол биеийн талтайг философичид, ялангуяа сонгодог философийн төлөөлөгчид зөвшөөрдөг нь ойлгомжтой. Ингэхдээ тэдний нэлээд нь хүний биологи талыг, хамгийн ерөнхийгөөр бол мэдрэгдэгч талыг тухайлж иржээ. Харин Ф.Ницше хүнийг өвөрмөцөөр тайлбарладаг байсан байна. Үүнд, тэрээр олон бүтээлдээ “бие” гэдэг үгээр мах цусан бодосыг биш, харин амьдралыг биежүүлэгч санааг тэмдэглэсэн байдаг юм. Жишээ нь: “Эзэрхэх хүсэл эрмэлзэл” нэрээр хэвлэгдсэн, улмаар дуусгаж амжилгүй нас барсан зохиолдоо тэрээр: «хүний бие бол бүх органик хөгжил дэх хамгийн алслагдсан зүйл, саяхны өнгөрсөн аль алиныг амьтай болгон, хэрэгжүүлж байдаг тийм санаа, тэхдээ хуучин «сэтгэл»-ийг бодвол илүү гайхашруулагч санаа мөн»¹ гэж тэмдэглэсэн байдаг. Тэгээд Ф.Ницше биеийн тухай яриа бол илүү дээд эрэмбийн санааны хөгжлийн тухай яриа мөн² гэсэн билээ.

Хүний биеийг нь тийнхүү “сэтгэл” хэмээн онцолж буй юм чинь түүний (хүний) бусад талыг сэтгэлийн тодорхой хэв маяг мөн гэж Ф.Ницше үзсэн нь ойлгомжтой. Ер нь хүний олон хэв маягийг тэрээр өгүүлсэн нь сэтгэлийнх нь өвөрмөц хэв маягийн үүднээс тэр бүгдийг илэрхийлсэн байдаг юм.

XX зуунд холбогдуулбал экзистенциализмын төлөөлөгчдийн боловсруулсан хүний тухай онолд агуулга, арга зүйн зарим ялгаа байдаг ч гэсэн бүхэлд нь аваад үзвэл тэдний онолд дараах зарим нийтлэг санаа байдаг. Үүнд: нэгдүгээрт, хүн яаж үүссэн асуудлыг биш, харин хүн гэж юу болохыг тайлбарлахыг чухалчилсан байна. Хоёрдугаарт, хүн бол оршихуй нь мөн чанарынхаа угтал болдог амьтан мөн. Гуравдугаарт, хүний оршихуй бол түүний(хүний) эрх чөлөө нь мөн. Дөрөвдүгээрт, эрх чөлөө харилцан хамааралд байдаг. Голруулж хэлбэл зөвхөн өөрийн төдийгүй бас бусдын эрх чөлөөг зөвшөөрч, зорилгоо болгож, хүсэж байгаа тийм нөхцөлд л өөрийнхөө эрх чөлөөг хүлээн зөвшөөрч болдог.

Товчоор хэлбэл экзистенциализмын боловсруулсан хүний тухай онол бол Би-гийн хууг төвөө болгож; хүн сонголтоо өөрөө хийж, эрх чөлөөт үйлдлийнхээ хувьд өөрийнхөө ба бусдын өмнө хариуцлага хүлээж; үүнийхээ улмаас түгшүүр, цөхрөл, хаягдсан байдалд байдаг хэмээгч психологичлогч, тийнхүү иррационалист онол юм.

Шашны философийн үзэл. Хүний тухай шашны философийн сургаалыг авч үзэхдээ эхнэр түрүүнд дэлхийн 3 гол шашин дахь философи үндэслэлүүдийг онцлох шаардлагатай. Тэхдээ энд буддын шашин, христос шашин хоёрынх нь холбогдох үзлийг онцлов. Учир нь ислам шашны холбогдох үзэл нь голлож Библи дэх Хуучин Гэрээний мэдээ сэлтүүдээс эх сурвалжтай байдаг билээ.

Буддын шашин ба гүн ухаанд “хүн” гэж юу болохыг хэрхэн тайлбарладаг нь бурхан багшийн айлдсан гол бүтээлийн нэг болох “Цагийн хүрдний номлол”-д нэлээд

Ф.Ницше. Воля к власти. Опы переоценки всех ценностей (1884-1888). Том 1. М., 1994. с. 265
Там же. с. 274

тодорхой байдаг. Тэнд ертөнцийн үүсэл, бүтэц тогтцын асуудлыг түүний (ертөнцийн) орших цаг хугацаатай уялдуулаж улмаар уг асуудлыг од гарагийн хөдөлгөөн, амьд амьтны амьдралын хэмнэлээр “гадаад”, “дотоод”, “бусад” хэмээх гурван утгаар авч үзсэн байдаг. Үүнд¹: “Цагийн хүрдний номлол”-ын “гадаад” хэмээх агуулгад орчлон ертөнцийн тогтоц, харин “дотоод” хэмээх агуулгад хүний биеийн бүтэц, хэмнэл голлон багтдаг бол “бусад” хэмээх агуулгад орчлон ертөнцийг танин мэдэж төгс гэгээрэлд хүрэх зэрэг асуудлыг багтаан оруулсан байдаг. Цагийн хүрдний номлолд хүний биеийг орчлон ертөнцийн салшгүй бүрэлдэхүүн хэсгийн хувьд авч үздэг байна. Буддын шашин ба гүн ухааны үүднээс орчлон ертөнц хий, гал, ус, шороо зэрэг махбодиос бүрддэг шиг хүний махбодь мөн эдгээрээс бүрддэг гэж энэ сударт үздэг байна.

Тийнхүү Цагийн хүрдний номлол дахь “Дотоод цагийн хүрд”-д хүний бие махбодийн бүтэц, оршин тогтнох ёсыг илэрхийлдэг. Дотоод цагийн хүрд нь хамгийн товчоор юу вэ? гэвэл почин жүни буюу хүн хоногт хамрынхаа 2 нүхээр ээлжлэн 2 цагийн зайтай хүчилтөрөгч хэмээх агаараар 21600 удаа амьсгалаад илүүдэл нүүрсхүчлийн хийг гаргадаг бөгөөд тэрхүү амьсгалсан агаарыг 2 цагийн давтамжтай ээлжлэн оруулж гаргаж; энд гаднаас ирсэн агаарыг 5 цул эрхтэн, ума, рома, жама судсаар дамжуулан авч бүхий л эд эсэд түгээж буцаан гаргадаг. Ийм утгаар хүний бие нь нэг ёсны хүрд юм. Тиймээс дотоод цагийн хүрд хэмээх ойлголт нь хүний биеийн системийг илэрхийлсэн ойлголт юм. Цагийн хүрдний номлолд хүний биед хамаарах ийм тодорхой мэдээнүүд элбэг байдаг нь мэргэ төлгийн шинжтэй биш, харин орчин цагийн биологи, ялангуяа анагаах ухааны нээлт ололтоор нотлогдож байдаг гайхамшигт айлдварууд юм. Жишээ нь, орчин үеийн физиологи, анагаах ухааны нотлон тайлбарладагаар, хүн бол хоол тэжээл идэн, хүчээ сэлбэж, өөртөө хэрэгтэй шим тэжээлийг аваад үлдсэнийг заавал бүдүүн шулуун гэдсээр дамжуулан гаргадаг нэг ёсны бяцхан үйлдвэр юм.

Өмнө нь өгүүлсэн хүрдний системийн тухай ойлголтоор бол хүний биед үндсэн 5 хүрд ба 12 туслах хүрд байдаг. Ийм үзэл нь орчин үеийн шинжлэх ухаанд хүний бие организмг дүрслэг, сүнслэг, гэрлэн бүрхэвч болон сүлдтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байгаагаар нотлогдож байна. Бурхны шашин ба гүн ухааны үүднээс хандвал хүний биед харагдах бодит байдлаас гадна олон нөлөөт хүчин зүйл байдаг. Харамсалтай нь олонх хүн нүдэнд харагдах бие махбодь, материаллаг ертөнц л бодит байгаа зүйлс гэж өрөөсгөлөөр боддог.

Ийнхүү хүний махбодон биеийн онцлогийн тухай Бурхан багшийн сургаалд үгүүлдэг чухал чухал мэдээ сэлт нь зөвхөн далдлаг, чанад, ер бусын зүйлсийг илэрийлсэн биш, мөн мэргэ төлгийн агуулгатай биш, харин өнөөгийн шинжлэх ухааны ололтоор нотлогдож байдаг тийм объектив үнэн агуулга бүхий юм.

Харин одоо хүний үүслийн тухай, хүн гэж юу болохыг Библид хэрхэн өгүүлснийг товч авч үзье.

Үүнд: Хуучин Гэрээнд өгүүлснээр Бурхан тэнгэр ертөнцийг бүтээснийхээ дараа «Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгөө адилхан хүнийг бүтээж, далайн загас огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхөгч бүгдийг тэдэн,

¹ Хүний тухай Бурхан багшийн сургаалын гол агуулгыг илэрхийлсэн манай сүүлийн үеийн нэг судалгааны бүтээлийн нэ дурдахад: Ц.Отгонбаяр. Цагийн хүрдний номлолыг нээх утга. Докторын диссертаци. УБ., 2009, Хоёрдугаар бүлэг (хүний тухай бурхны шашны үзлийн агуулгыг бид өгүүлэлдээ илэрхийлэхдээ энэхүү судалгааны бүтээлийг голлон ашиглав).

захируулъя хэмээн айлдав. Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурхны дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв. Бурхан тэднийг адислаж, тэдэнд өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэн газрыг эзэмш! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дэлхий дээр хөдөлдөг бүх амьтдыг захир хэмээн айлдав»¹ гэж 1:27-28-д өгүүлсэн байдаг. Улмаар энэ мэдээг христос шашны ХХ зуун дахь өөр өөр философи чиглэл бие биеэсээ ялгаатай тайлбарлах болсон байна. Тухайлбал неотомизмын үүднээс хүн бол байгалийн биш, харин Бурхан тэнгэрийн өөрийнх нь бүтээл мөн. Гэтэл энэ философийн өөр нэг чиглэл тейярдизмын үүднээс хүний үүсэл бол орчлонгийн хувьсал Омега цэг рүү чиглэн дэвшиж байдгийн үр дүн мөн бөгөөд хүн төрөлхтний туулж ирсэн урагшлах шатууд ба ирээдүйн дэвшил бол Омега цэг рүү улам улам ойртох явдал мөн юм. Энд гарч буй “Омега цэг” гэдэг ойлголт Библи дэх Бурхан тэнгэрийг төлөөлдөг. Тийнхүү тейярдизм хүнийг Бурхан тэнгэрийн бүтээл гэж үл тайлбарлаж, харин түүн (Бурхан тэнгэр) лүү чиглэн ойртож байдаг хувьслын үр дүн, гэхдээ ургамал, амьтны ертөнцийн дээр нь улам бүр гүнзгийрч байдаг тийм оюун ухаант (рефлексив) давхраа, үүнд үхэл нь хүртэл Омега цэг рүү сүнсээрээ ойртдог давхраа мөн.

Харьцуулан дурдахад хүн бол неотомизмын үүднээс Бурхан тэнгэртэй төсөөтэй ч түүнээс доошлон холдсон үр дүн, харин тейярдизмын үүднээс Бурхан тэнгэр лүү ойртож буй хувьслын шат мөн.

Энэ мэтээр янз бүрийн шашны философи хүн гэж юу болохыг бие биеэсээ тодорхой ялгаатай тайлбарладаг.

Дээр өгүүлсэн зүйлсээсээ дүгнэн дурдахад хүний тухай өөр өөр философийн болон шашны тайлбарууд нь хүн гэж юу болох, түүний үүслийн шалтгаан юу байдаг зэрэг шинжлэх ухаан дахь маргаантай асуудлыг шийдвэрлэхэд арга зүйн нэгдмэл үндэс огтхон ч болдоггүй.

Хамгийн ерөнхийгөөр хэлэхэд хүний үүслийг шинжлэх ухааны үүднээс тайлбарласан эсрэг тэсрэг хоёр үзэл орчин үед байдаг. Тэдгээрийн нэг нь Ч.Дарвины үзэлд тулгуурласан хувьслын онол, нөгөөх нь хувьслын онолыг үл зөвшөөрөгч оккультивизм, спиритуализмын тодорхой үзлийг зөвтгөдөг шинжлэх ухааны мэдлэг (оккультив шинжлэх ухаан) юм.

Хүний үүслийн тухай манай сургалтын практикт хамгийн өргөн нэвтэрсэн шинжлэх ухааны мэдлэг бол английн эрдэмтэн Ч.Дарвины (1809-1882) онол юм. Тэрээр хүний үүслийн шалтгааныг тухайн үеийнхээ холбогдох эмпирик мэдлэгийн төвшин ба хүрээнд нэн няхуур судлан тайлбарласан байна. Түүний сургаал бол бүр дунд сургуулийн сурагч нарт танил байдаг тул энд түүний агуулгыг илэрхийлэх, бүрэн тайлбарлах зорилго тавиагүй болно. Тиймээс философи мэдлэгт шууд холбогдож ирсэн зөвхөн тийм зарим зүйлийг нь энд дурдъя. Үүнд: амьд биеийн зүйлүүд өөрчлөгддөг, удамшил, үр удамын нөхөн үйлдвэрлэл зэрэг туршлага дээр тогтоогддог баримтууд Дарвины онолын үндэс болдог. Амьд биест амьдралын төлөөний тэмцэл явагдаж, ийм тэмцэлд тэсэх чадваргүй нь устаж, харин тэсэж чадсан (өөрөөр хэлбэл байгалийн шалгарлыг давсан) нь орчиндоо зохицон, үр удмаа нөхөн үйлдвэрлэж, түүндээ удмын шинжүүдээ дамжуулж байдаг.

¹ Ариун Библи. Хуучин Гэрээ. Шинэ Гэрээ. Монголын Библийн орчуулгын хороо. 2002 он. Хуучин Гэрээ. 2 дахь тал

Ч.Дарвин амьтнаас хүн болох үйл явц тасралтгүй явагддаг гэж нотолжээ. Түүний үзлээр хүний онцлог шинжүүд нь 3 миллиард гаруй жилийн өмнө эхэлсэн биологийн өөрчлөлтийн явцад дэлхий дээр амьдрал үүсэх яг тэр үед эхээ авсан аж.

Гэвч Ч.Дарвины сургаал үүссэн даруйгаасаа л онолын үүднээс үл зөвшөөрсөн явз бүрийн дуу хоолойтой тулгарч ирсэн байдаг. Тийм дуу хоолойны нэг хэсэг нь ертөнцийг үзэх үзлийн ялгаанаас; өөр нэг хэсэг нь Ч.Дарвины өгүүлсэн онолын дүгнэлтийг няцаасан туршлагын баримтууд гарч ирэх болсонтой¹; бас өөр зарим хэсэг нь Ч.Дарвины онолоос нийгмийн онолын утга бүхий бие биеэсээ ялгаатай дүгнэлт гаргах болсонтой тус тус холбоотой байдаг.

Хэдий тийм боловч өнөөгийн хүн нь мичний зүйлийн амьтнаас үүсэлтэй хэмээх Ч.Дарвины онолыг баримталдаг судлаачид өнөө ч байгаа билээ. Тийм судлаачдын зарим нь хүн мичнээс 4-5 сая жилийг эзэлсэн хувьслын шатууд дамжин үүссэнийг дараах байдлаар илэрхийлжээ. Үүнд:

- Australopithecine*
- Homo habilis (чадварлаг хүн)
- Homo erectus (босоо явагч хүн)
- Homo sapiens (оюун ухаант хүн) гэсэн 4 шат дамжсанаар тайлбарладаг².

Гэвч энэ ангилал гэгч бол Ч.Дарвины онолтой тохирдоггүй, зохиомол шинжтэй гэсэн үзэл бас байдаг. Тухайлбал англи, америк зэрэг зарим орны судлаачид Homo habilis бол Homo (хүн) биш, харин Australopithecus-ийн төрөлд багтах нэгэн төрөл мич бөгөөд зөвхөн Homo erectus, Neandarthals, улмаар Homo sapiens 3 бол Homo төрөлд багтана гэсэн дүгнэлт хийж, түүгээр зогсохгүй зарим эрдэмтэн: "Homo erectus" гэдэг бие даасан зүйл байгаагүй хэмээн үзсэн байдаг³.

Хүний үүслийн тухай асуудал шийдлийн хувьд тийнхүү ихээхэн маргаантай, антропологи, палентологийн үүднээс ч нэг мөр биш байгааг орчин үеийн жин даах ном бүтээлүүдэд тэмдэглэж иржээ. Тухайлбал, "Дэлхийн түүх" хэмээх бүрэн хэмжээний лавлах номонд, «хүн анх хэзээ үүсэн бий болсныг хэн ч мэдэхгүй. Бидэнд мэдэгдэж байгаа ганц сэжүүр бол чулуужсан яс, чулуужсан зэвсэг юм. Хүний хувьсал ойролцоогоор 6 сая жилийн тэртээгээс Африкт эхэлжээ. Хүн нь бичин овгийнх ба энэ овогт хүнээс гадна мич, сармагчингууд багтдаг. Одоо амьдарч буй бичин овгийнхоос хүний хамгийн ойрын төрөл нь Шимпанзе юм»⁴ хэмээн бичсэн байх юм.

Товчоор хэлэхэд Ч.Дарвины онол маш олон зүйлийг тайлбарлаж чадаагүй, хувьслын үйл явцын талаархи тайлбарууд олон тохиолдолд зөрчилдөж байдаг.

¹ Үүнд хамааралтай нэг өгүүллийн нэр дурдахад: Ц.Эрдэнэбат, Г.Эрдэнэбаяр. -Хувьслын онолын хуудууны тухай асуудалд. -Философи, шашин судлал, VII. УБ., 2007. №288(41). 128-132 дахь тал

* "Australopithecus" гэдэг нэр томъёо бол Африкийн өмнөд нутгаас олдсон бөгөөд хүний хамгийн анхны нэг өвгийн нэр хэмээн энэ ангиллыг зохиогчид үздэг. Энэ амьтан өдгөөгөөс 4 сая жилийн тэртээгээс 1 сая жил хүртэл хугацаанд амьдарч байсан аж.

² Ийм ангилал хийсэн бүтээлүүдийн нэгийг дурдахад: Harun Yahya. Evolution deceit Kultur. 2001. p. 38

³ That book, p. 86-99

⁴ Дэлхийн түүх (бүрэн хэмжээний зурагт лавлах. Соёл иргэншлийн үүрийн гэгээнээс өнөөдрийг хүртэл). Ерөнхий редактор Адам Харт-Девис. Орч. Ред. Б.Батчулуун. Монсудар хэвлэлийн газар. УБ., 2009. 17 дахь тал

Хүний үүслийн тухай Ч.Дарвины боловсруулсан хувьслын сургаалыг төдийгүй орчин үеийн хувьслын онол, бас энэ онолыг шүүмжилдэг шинжлэх ухааны үзэл зэргийг орчин үеийн оккультив шинжлэх ухаан үл зөвшөөрдөг юм.

Соёл судлал дахь “оккультивизм” гэдэг нэр томъёо аваас гэгээнтэн хүмүүс болон тусгай бясалгал хийж, ер бусын чадвар эзэмшсэн хүмүүс байгаль дахь (эгэл хүмүүст) хүртээлгүй, далдлаг хүч, үзэгдэл үйл явдлыг дотоод мэдрэмжээрээ илрүүлсэн мэдлэгийг илэрхийлдэг бол “оккультив шинжлэх ухаан” гэдэг нэр томъёо нь оккультив мэдлэгийн зарим чухал үндэслэлийг шинжлэх ухааны үүднээс нотолж байгаа үр дүнг илэрхийлдэг. Иймд оккультив шинжлэх ухаан бол шинжлэх ухааны танин мэдэхүйгээс илүү их багтаамж, гүн агуулга бүхий мэдлэг бий болгож чаддаг.

Орчин үед хүний үүслийг тайлбарлахтай холбоо бүхий бий болсон оккультив шинжлэх ухааны нэг том төлөөлөгч бол оросын эрдэмтэн, нүдний эмч, судлаач Э.Ф.Мулдашев юм. Түүний үндэслэсэн оккультив шинжлэх ухаан нь хүн мичнээс үүсээгүйг нотлох зорилт тавьдаг. Ийм зорилтыг Э.Ф.Мулдашев тавихдаа дэлхийн томоохон шашнуудын, түүний дотор буддын шашны холбогдох мэдээнүүдийг чухал эх сурвалж болгожээ. Бас зарим гэгээнтний бичсэн ном дахь чухал мэдээ болон судалгааны аяллынхаа шугамаар төвд, энэтхэг, балбын лам нартай хийсэн ярилцлага зэргээсээ орчин үеийн хүн үүссэн шалтгааныг тайлбарлах үндэслэгээ олж авчээ.

Оросын энэ эрдэмтэн хүн яаж үүссэнийг дараах байдлаар тайлбарласан юм. Үүнд: «Газар дэлхийн амьдрал сүнсний нягтралаар үүссэн байна. Сүнс нягтрах үйл явц олон сая жил үргэлжилжээ. Анхны хүмүүс (сүнс маягийн хүмүүс) бодит бие махбодтойгоосоо илүү сүнслэг байжээ. Гэхдээ тэд маш сийрэг бодит бие махбодийнхоо мэдээллийг нахиалах, хуваагдах замаар дамжуулах зориулалттай анхдагч генийн цогц байсан юм. Анхны хүмүүс сансрын долгионы хуулиар амьдардаг байсан ч газар дэлхийн хүмүүс гэхээсээ илүү Нөгөө Ертөнцийн элч төлөөлөгч мэтээр төсөөлдөг байлаа. “Сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” гэсэн ойлголт тэдний хувьд газар дэлхийн бодит асуудлаас хамаагүй чухал байжээ.

Хоёр дахь иргэншлийн (хий үзэгдэл маягийн) хүмүүс үндсэндээ нэгдүгээр иргэншлийн хүмүүс мэт амьдардаг байсан ч тэдний газар дэлхийн бодит бүрхүүл нь илүү нягт, бие махбодод уламжлуулан дамжуулах генийн цогцын аргачлал нь илүү төгс төгөлдөр байжээ.

Гурав дахь иргэншлийн хүмүүс (лемурчууд) нь илүү нягт, төгс төгөлдөр бодит биетэй, эхэн үедээ дөрвөн гар, хоёр нүүртэй аварга байсан ба хожуу үедээ хоёр гар, нэг нүүртэй аврага биетэн болсон байна. Лемурын биед шингэсэн сүнс Нөгөө Ертөнцтэй холбоогоо бүрэн хадгалж байжээ. Тиймээс “SoHm”-ын буюу “Өөрсдөө боловсор” гэдэг зарчим үйлчилдэггүй байлаа. Лемур хүн нь илүү өндөр зохион байгуулалттай Нөгөө Ертөнцийн хууль, зарчмаар амьдардаг байсан ч бодит ертөнц дэх идэвхтэй үйл ажиллагаа нь түүнийг энгийн ахуйн асуудалд ч анхаардаг, болгожээ.

Дөрөв дэх иргэншлийн хүмүүс (атлантчууд) Нөгөө Ертөнцтэй холбоогоо хадгалсаар байсан боловч газар дэлхийн энгийн ахуйн асуудал тэдэнд илүү ойр дотно болжээ. Нөгөө Ертөнцийн “сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” болон бусад

ойлголт хойш ухарч, бодит бие махбодийн хэрэгцээ болох идэх, уух, унтах гэх мэт зүйлс илүү сонирхол татдаг болжээ.

Тав дахь иргэншлийн хүмүүс болох бид бол физик биеийнхээ боол юм. Нөгөө Ертөнцөөс “SoHm”-ын зарчмаар тусгаарлагдсан сүнс Нөгөө Ертөнцтэй холбох нэгтгэх үүргийг бус, харин бие махбодийг оршин тогтнох үүргийг гүйцэтгэдэг болжээ. Нөгөө Ертөнцийн гол оршихуй болсон “сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” зэрэг үзэгдэл зөвхөн зөн совингийн шивнээ төдийгөөр илэрдэг болов»¹ гэсэн байдаг.

Лемур хүн, атлант хүний иргэншил сөнөсөн шалтгаан гэвэл тэдгээр хүмүүс сэтгэлийн ба биеийн үйлдлийн нүглээсээ болж дэлхийгээ сүйрүүлж, иргэншлээ сөнөөсөн гэж Э.Ф.Мулдашев бичсэн байдаг. Тэгээд манай дэлхийн өнөөгийн хүн төрөлхтөн бол шинжлэх ухааны ба философийн зарим төлөөлөгч тайлбарладагчлан мичнээс үүссэн биш, харин сөнөсөн иргэншлүүдийн амьд хоцорсон хүмүүсийн бууран доройтож, зэрлэгшсэн үүлдэр мөн гэсэн дүгнэлтийг тэрээр хийжээ. Яагаад хүн төрөлхтөн сөнөсөн удмаасаа дордсон бэ? гэвэл тэдгээр иргэншлээс манай хүн төрөлхтний өвөг болж тэсэн үлдсэн лемур-атлант хүмүүс дэлхийн сүйрэл, усан галав зэргийн аймшигт нөхцөлд нэрвэгдсэнээс тийм доройтолд орсон гэж ганц Э.Ф.Мулдашев биш, ер нь оккультив шинжлэх ухааны олон төлөөлөгч тайлбарладаг байна.

Сүүлийн үед монголын зарим зохиогч хүн хэрхэн үүссэн тухай оккультив шинжлэх ухааны тайлбарыг бас сурталчилж байна. Жишээ нь: Г.Армаа бичсэнийг дурдахад, «Өнөөдөр бид “хүн” хэмээх категорид хоёр өөр төрөл зүйлийн бодгалийг хамаатуулж байна.

1. Төрөл дамжиж хувьсан өөрчлөгдөөгүй, шууд биежсэн “Тэнгэр” буюу хэт ухаантай Үлэмж биет хүмүүс

2. Жирийн ухаант хүн буюу шинжлэх ухааны хэлээр Хомо сапиенс (оюун ухаант хүн). Хүмүүс энэ 2 төрлийг нэг мэтээр ухаарч, ярьж бичигддэг. Гэтэл тийм биш. Харин Үлэмж биетнүүдийн оролцоотой, тэдний жолоодлогоор Хомо сапиенс үүссэн гэж баттай хэлж байна»².

Өгүүллийнхээ төгсгөлд бид өөрсөддөө дараах асуулт тавиад түүндээ мөн өөрсдөө хариулт өгье. Асуулт: хүний үүслийн шалтгааны тухай хувьслын онол, түүнийг үгүйсгэдэг оккультив шинжлэх ухааны тайлбар хоёрын аль нь эдүгээ үнэн бэ? Хариулт: хүн үүссэн шалтгааны тухай Ч.Дарвины сургаалын олон үндэслэл шинжлэх ухааны үүднээс няцаагдаж байгаа ч гэсэн бүхэлд нь аваад үзвэл уг асуудлаархи хувьслын онол, оккультив шинжлэх ухааны мэдлэг аль аль нь (өөрийгөө зөвтгөн хамгаалсан үндэслэгээ гаргадаг ч гэсэн) нийтэд хангалттай зөвшөөрөгдөх юм уу бүрэн няцаагдах байдалд хүрэхгүй байгаа билээ.

Резюме: В статье под заглавием «Отдельные соображения относительно человека и причины его происхождения» авторы классифицировали различные философские концепции о человеке, сравнительно анализировали философские взгляды по вопросам причины происхождения человека. По их выводам, как эволюционная теория, так и оккультивистская наука хотя проводят собственные основания, предназначенные для оправдания своих положений по вопросам причины происхождения человека, оба с

¹ Э.Ф.Мулдашев. Хүн мичнээс үүсээгүй. Орчуулсан М.Пүрэвжав. УБ., 2005 номноос энэ тухай үзнэ үү.

² Г.Армаа. Хүний үүсэл. УБ., 2009. 14 дэх тал

полностью не испытывают ни широкой поддержки, ни категорического опровержения в среде научного мира.

Ном зүй

- Ариун Библи. Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ. Монголын Библийн орчуулгын хороо, 2002
- Г.Армаа. Хүний үүсэл. УБ., 2009
- Дэлхийн түүх (бүрэн хэмжээний зурагт лавлах. Соём иргэншлийн үүрийн гэгээнээс өнөөдрийг хүртэл). Ерөнхий редактор. Адам Харт Девис. Орч. Ред. Б.Батчулуун. Монсудар хэвлэлийн газар. УБ., 2009
- К.Маркс. Фейербахын тухай сэдвүүд.-К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. I боть. УБ., 1969
- Э.Ф.Мулдашев. Хүн мичнээс үүсээгүй. Орчуулсан М.Пүрэвжав. УБ., 2005
- Ц.Отгонбаяр. Цагийн хүрдний номлолыг нээх утга. Докторын диссертаци. УБ., 2009
- Ф.Энгельс. Мич хүн болоход хөдөлмөрийн гүйцэтгэсэн роль.-Ф.Энгельс. Байгалийн диалектик. УБ., 1986, 145-157 дахь тал
- Ц.Эрдэнэбат, Г.Эрдэнэбаяр. Хувьслын онолын хуудууны тухай асуудалд. Философи, шашин судлал, VII. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2007. №288(41)
- Ф.Ницше. Воля к власти. Опыт переоценки всех ценностей (1884-1888). Том 1. М., 1994
- Ф.Ницше. Так говорил Заратустра. Книга для всех и ни для кого.-Фридрих Ницше. Сочинения в двух томах. Том 2. М., 1990. Часть первая
- Harun Yahya. Evolution deceit. Kultur. 2001